

ДОТООД АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм", 2024 оны 214 дүгээр тогтоолоор баталсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам", Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Хууль зүйн яам, түүний харьяа агентлаг, байгууллагын дотоод аудитын журам"-ын хүрээнд байгууллагын даргын 01-08/10 дугаар удирдамжийн дагуу энэ оны гуравдугаар улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.

Байгууллагуудыг дэлгэрэнгүйгээр өссөн дүнгээр харуулбал:

д/д	Байгууллагууд	Системд бүртгэлтэй байгууллагын тоо	Мэдээлэх давтамж	Хугацаандаа	Хугацаа хоцорсон мэдээлэл	Хугацаа болоогүй	Хувь
1	2	3	4	5	5	6	7
1	Гадаадын иргэн, харьяатын газар	1	135	134	1	-	99.2
2	Агаарын замын боомт хариуцсан газар	1	135	135	-	-	100.0
3	Дорноговь аймаг дахь газар	1	135	135	-	-	100.0
4	Хойд бүс дэх газар	1	135	135	-	-	100.0
5	Өмнөд бүс дэх газар	1	135	135	-	-	100.0
6	Баруун бүс дэх газар	1	135	135	-	-	100.0
7	Зүүн бүс дэх газар	1	135	135	-	-	100.0
8	Баян-Өлгий аймаг дахь хэлтэс	1	135	135	-	-	100.0
Нийт дүн		8	1080	1079	1	-	99.9

Байгууллагын хэмжээнд тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа санхүүгийн үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалтын холбогдох мэдээллийг цахим хуудсанд 3 ангиллаар 29 төрлийн 1080 мэдээлэл байршуулахаас 1079 мэдээллийг хуулийн хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроон байршуулан 99.9 хувийн хэрэгжилттэй буюу "Хангалттай" хэмжээнд байна.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг үнэн зөв, бодитой, иж бүрэн тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлж, хуулийн хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх шаардлагатай. Үүнд:

Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрт мэдээлэх гэсний дагуу байгууллагын даргын баталсан 07 дугаар сарын 29-ний өдрийн А/341, А/342, 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/401 дүгээр тушаалыг тус тус бүрэн мэдээлэх;

Дотоод аудитын зөвлөмж, удирдлагаас хүргүүлсэн үүрэг чиглэлийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т “Шилэн дансны тухай хууль тогтоомж зөрчсөн төсвийн байгууллагын албан тушаалтанд зөрчлийн шинж байдлыг харгалзан Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах тул холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг зөвлөж байна.

Зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаанд нь Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын нэгжид албан бичгээр ирүүлнэ үү.

---oooOooo---